

БАТЛАВ
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД
С.БЯМБАЦОГТ

2022 оны 10 сарын 06 өдөр

ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН “ЗУУНЫ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ” ШИНЭ САНАА, ШИЛДЭГ ШИЙДЭЛ ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНЫ УДИРДАМЖ

2022 оны 10 дугаар сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

Нэг. Зорилго

Зам, тээврийн салбарт түүхэнд дуурсагдах бүтээн байгуулалтын оновчтой шийдэл, урт хугацаанд хэрэгжүүлэх бодлогын санал, шинэ санаа, дэвшилтэт технологи, инновац нэвтрүүлэх зорилгоор Зам, тээврийн салбарын “Зууны бүтээн байгуулалт” шинэ санаа, шилдэг шийдэл шалгаруулах уралдааныг зохион байгуулна.

Хоёр. Хамрах хүрээ

Уралдаанд Зам, тээврийн хөгжлийн яам, түүний харьяа байгууллагуудын ажилтан, албан хаагчид оролцоно.

Гурав. Хугацаа

2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хооронд.

Дөрөв. Бүтээлд тавигдах шаардлага.

Оролцогчид бүтээлийг дараах 2 чиглэлээр ирүүлнэ. Үүнд:

1. Зуун дамжин дуурсагдах томоохон бүтээн байгуулалтын оновчтой санал, шилдэг шийдэл.
2. Салбарын хэмжээнд ойрын хугацаанд нэвтрүүлж болох шинэ техник, технологи, инновацын бүтээлийн санал.

Ирүүлэх бүтээл нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Зуун дамжин дуурсагдах томоохон бүтээн байгуулалтын оновчтой санал, шилдэг шийдэл:

- Монгол Улсын зам, тээврийн салбарын хөгжилд түүхэн ахиц дэвшил гаргахуйц, ирээдүйн чиг хандлагыг тодорхойлсон, бодит үр дүнд чиглэсэн байх;
- Нийгэм, эдийн засгийн үр өгөөж, хүрэх түвшинг тооцоолсон байх;

- Зам, тээврийн салбарын уялдаа холбоог хангасан байх;
- Шийдвэрлэх арга зам, хэрэгжүүлэх ажлуудыг нарийвчлан тодорхойлж, шаардлагатай хөрөнгө оруулалтыг тооцоолсон байх.

2. Шинэ техник, технологи, инновацын бүтээл:

- Шинэлэг санаа , олон улсад нэвтэрсэн, Монголд нутагшуулах боломжтой байх;
- Хөдөлмөр хөнгөвчлөх, бүтээмж нэмэгдүүлэх, нөөцийг хэмнэх, байгаль экологид ээлтэй шийдэл агуулсан байх.
- Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд тулгуурласан байх;
- Байгууллага/ салбарын үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх боломжтой байх;
- Импортын бараа, бүтээгдэхүүнийг орлохуйц байх.

Тав. Бүрдүүлэх материал.

1. Бүтээлийн танилцуулгыг файлаар болон цаасаар 2 хувь ирүүлнэ.

Зургаа.Шалгаруулалт

1.Шалгаруулалтад нэр дэвшүүлж буй бүтээл нь тавигдах шаардлага, зохих бүрдүүлэлтийг хангасан байх ба бүрдүүлсэн материал, баримт бичгийг файлаар болон цаасаар Зам, тээврийн хөгжлийн яамны угтах үйлчилгээнд 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 9.00 цагаас 11 дүгээр сарын 14-ний өдрийн 18.00 цагийн дотор хүлээн авч, Сонгон шалгаруулалтын комисс шалгаруулж, олон нийтэд нээлттэй зарлана.

2.Бүтээлийг дүгнэх, шалгаруулах журмыг Сонгон шалгаруулах комисс тогтооно.

3.Уралдаанд шалгарсан шилдэг бүтээлийн эздэд зохиогчийн эрхийг эзэмшүүлнэ.

Долоо. Шагналын сан.

Шилдэг бүтээлээр шалгарсан эхний 20 бүтээлийн эзэнд Зам, тээврийн хөгжлийн сайдын нэрэмжит шагнал гардуулж, үнэ бүхий зүйлээр урамшуулна.